



**НИЙСЛЭЛИЙН
ӨМЧИЙН АШИГЛАЛТ, УДИРДЛАГЫН ГАЗРЫН
ДАРГЫН ТУШААЛ**

2020 оны 06 сарын 08 өдөр

Дугаар 01255

Улаанбаатар хот

Баянзүрх дүүргийн 52 дугаар
цэцэрлэгийн хөрөнгийг
данснаас хасах тухай

Монгол Улсын Засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 33 дугаар зүйлийн 33.5 дахь хэсэг, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 31 дүгээр зүйлийн 31.1 дэх хэсэг, 80 дугаар зүйл, Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2014 оны 66 дугаар тогтоолын хавсралтаар батлагдсан “Нийслэлийн өмчит хуулийн этгээдийн эд хөрөнгийн хөдөлгөөн, түүнтэй холбогдох бусад харилцааг зохицуулах журам”-ын 4 дүгээр зүйлийн 4.6 дахь хэсгийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. “Эргэлтийн бус хөрөнгийн хөдөлгөөн хариуцсан комисс”-ын 2020 оны 06 дүгээр сарын 04-ний өдрийн хурлын шийдвэрийн дагуу эргэлтийн бус хөрөнгийн дансанд бүртгэлтэй нийт 1,504,669.00 /нэг сая таван зуун дөрвөн мянга зургаан зуун жаран ес/ төгрөгийн бүртгэлийн үнэ бүхий хавсралтад заасан хөрөнгийг акталж, данс бүртгэлээс хасахыг Баянзүрх дүүргийн 52 дугаар цэцэрлэг /З.Энхтуяа/-т зөвшөөрсүгэй.

2. Данснаас хасагдаж буй эргэлтийн бус хөрөнгөнөөс, 5 нэр төрлийн 1,504,669.00 /нэг сая таван зуун дөрвөн мянга зургаан зуун жаран ес/ төгрөгийн бүртгэлийн үнэ бүхий хөрөнгийг байгууллагын Өмч хамгаалах байнгын зөвлөлийн хяналтан дор устгалын акт үйлдэн зохих журмын дагуу устган, өмчийн мэдээллийн санд хөрөнгийн хөдөлгөөний холбогдох өөрчлөлт хийж ажиллахыг Баянзүрх дүүргийн 52 дугаар цэцэрлэг /З.Энхтуяа/-т үүрэг болгосугай.

3. Татан төвлөрүүлж буй хөрөнгийг худалдан борлуулах ажлыг зохион байгуулахыг Захиргаа санхүүгийн хэлтэс /А.Мөнгөн/-т үүрэг болгосугай.

4. Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Орлогч дарга Д.Төмөрбаатарт даалгасугай.

ДАРГЫН ҮҮРЭГ
ГҮЙЦЭТГЭГЧ

Ш.ҮНЭНБАТ

115050000633

Нийслэлийн Өмчийн Ашиглалт Удирдлагын газрын
даргын 2020 оны 06 сарын 08 өдрийн
0685... дугаар тушаалын хавсралт

Данснаас хасах эд хөрөнгийн жагсаалт

Байгууллагын нэр: Баянзүрх дүүргийн 52 дугаар цэцэрлэг

/төгрөгөөр/

№	Эд хөрөнгийн нэр	Ашигласан жил	Хэмжих нэгж	Тоо хэмжээ	Нэгжийн үнэ	Нийт үнэ	Байгуулсан элэгдэл	Үлдэгдэл үнэ	Эвдрэл гэмтэл	ӨХБЗ-ийн дүгнэлт	ЭБХХЖ-ийн шийдвэр
Программ хангамж											
1	Программын үнэ	17	ш	1	249,169.00	249,169.00	249,169.00	-	Ашиглах боломжгүй	Устгах	устгах
2	Санхүүгийн программ	14	ш	1	402,500.00	402,500.00	402,500.00	-	Ашиглах боломжгүй	Устгах	устгах
3	ҮХ программ	11	ш	1	180,000.00	180,000.00	180,000.00	-	Ашиглах боломжгүй	Устгах	устгах
4	Санхүүгийн программ	11	ш	1	462,000.00	462,000.00	462,000.00	-	Ашиглах боломжгүй	Устгах	устгах
5	Санхүүгийн программ	10	ш	1	211,000.00	211,000.00	211,000.00	-	Ашиглах боломжгүй	Устгах	устгах
Программ хангамжийн дүн						1,504,669.00	1,504,669.00	-			
Нийт дүн						1,504,669.00		-			
Устгах хөрөнгийн дүн						1,504,669.00	1,504,669.00	-			